

“Улаанбаатар БҮК” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2013 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн
2013/28 тоот тогтоолын хавсралт



**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫГ
ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлах, хуралдуулах, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хурлын бүрэн эрх, хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах журам, хурлын дэг, хурлын тэмдэглэл, шийдвэрийг баталгаажуулах, хуралтай холбоотой хувьцаа эзэмшигчийн гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид “Хурал” гэх) нь Компанийн тухай хууль, компанийн дүрмээр тодорхойлсон бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцэн, шийдвэр гаргах, компанийн үйл ажиллагаа, ололт амжилт, тулгарч буй бэрхшээл, цаашдын төлөвлөгөөний талаар хувьцаа эзэмшигчиддээ мэдээлэх зорилготой байна.
- 1.3. Хурал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдоггүй хувьцаа эзэмшигчдийн хувьд компанийн үйл ажиллагааны талаар бүрэн мэдээлэл олж авах, удирдлага, эрх бүхий албан тушаалтан, хөндлөнгийн аудиторт асуулт тавьж, хариулт авах, тэдгээрийн үйл ажиллагаа, мэдлэг чадварын талаар үнэлэлт өгөх боломж олгоно.
- 1.4. Хуралд оролцсоноор хувьцаа эзэмшигч нь компанийг удирдах үйл ажиллагаанд оролцох эрхээ хэрэгжүүлнэ.
- 1.5. Хувьцаа эзэмшигчдийн итгэлийг хүлээж, хурлыг бүх хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах зарчмаар зохион байгуулан хувьцаа эзэмшигч бүр хуралд оролцох, санал өгөх боломжийг хангах нь ТУЗ-ийн үүрэг байна.

**ХОЁР. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ
ШИЙДВЭР ГАРГАХ, ХУРЛЫН ЗАР МЭДЭЭГ ХҮРГЭХ,
БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ**

- 2.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас дөрвөн сарын дотор ТУЗ зарлан хуралдуулна.
- 2.2. ТУЗ нь жил бүрийн 3 дугаар сарын 10-ний дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хуралдуулах тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 2.3. Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах асуудлыг заавал тусгасан байна. Үүнд:
 - 2.3.1. хурлыг хуралдуулах газар, өдөр, цаг;
 - 2.3.2. хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;
 - 2.3.3. хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр /энэ өдөр нь энэхүү журмын 2.6-д заасны дагуу хурал хуралдуулах тухай зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 10 дахь өдөр байхаар тогтооно/;
 - 2.3.4. хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр журам;
 - 2.3.5. хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийн жагсаалт;
 - 2.3.6. санал авах хуудасны агуулга;
 - 2.3.7. саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр, цаг;
 - 2.3.8. хурлын дарга;

2.3.9. тооллогын комиссын дарга, гишүүд.

2.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.

2.5. Ээлжит хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор буюу жил бүрийн 3 дугаар сарын 13-ны дотор “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг энэхүү журмын хавсралт маягтаар Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлнэ. Мэдэгдэлд дараах материалыг хавсаргана. Үүнд:

- 2.5.1. хурал хуралдуулах тухай шийдвэр;
- 2.5.2. хурлын талаар олон нийтэд хүргэх зарын загвар;
- 2.5.3. саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 66.1-д заасны дагуу хурлын хэлэлцэх асуудалд санал оруулсан бол түүний хуулбар;
- 2.5.4. хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, хуулбар.

2.6. Хурал зарлагч нь хурлын зарыг хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор буюу жил бүрийн 3 дугаар сарын 13-ны дотор олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” зэрэг хоёроос доошгүй өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизэд нийтлүүлэх буюу нэвтрүүлэхээр хүргүүлж, компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд тавина. Хурлын зар мэдээг дээр дурдсан арга хэрэгслээр, дурдсан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд хүргээгүйг энэ журмыг зөрчсөн гэж үзнэ. Компани хувьцаа эзэмшигчдийн цахим шуудангийн хаягийн сан бүрдүүлэн хурлын зар мэдээ болон хөрөнгө оруулагч, олон нийтэд хүргэх мэдээллийг цахим шуудангийн хаягаар нь хүргэж болно.

2.7. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь сонирхсон хувьцаа эзэмшигчдийг хурлын зар мэдээ, гаргах шийдвэрийн төсөл, тэдгээртэй холбогдох болон хуралд оролцох эрхтэй этгээдийн талаархи мэдээлэлтэй танилцах, бусад хувьцаа эзэмшигчидтэй санал солилцох боломжоор хангаж, хурлын бэлтгэлийг хариуцан зохион байгуулна.


2.8. ТУЗ хурлын тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх зорилгоор компанийн хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер, дилерийн компаниудад энэ журмын 2.3, 2.5-д заасан мэдээллийг хурлын зарыг олон нийтэд хүргэсэн өдөр нэгэн зэрэг буюу жил бүрийн 3 дугаар сарын 13-ны дотор хүргүүлнэ. Түүнчлэн бүртгэх өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад үндэслэн “Санал авах хуудас”-ыг дээр заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.

2.9. Компани энэ журмын 2.8-д заасан мэдээлэл, саналын хуудсыг брокер дилерийн компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэх саналын хуудсыг баталгаажуулах, компанид буцаан ирүүлэх хугацаа, журам, үйлчилгээний хөлс төлөхтэй холбоотой талуудын үүргийг тодорхойлсон гэрээг брокер, дилерийн компаниудтай байгуулж ажиллана.

2.10. Энэ журмын 2.5.2-т заасан хурлын талаар олон нийтэд хүргэх зар нь хувьцаа эзэмшигч хуралд ямар журмаар оролцохоо /биечлэн, саналын хуудсаар саналаа хүргэх, хэн нэгэнд итгэмжлэл олгөн төлөөлүүлэх /шийдвэрлэхэд шаардлагатай дараах мэдээллийг заавал агуулсан байна:

- 2.10.1.компанийн оноосон нэр, хаяг, байршил
- 2.10.2.хурал хийх, өдөр, цаг, газар
- 2.10.3.бүртгэх өдөр
- 2.10.4.хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт
- 2.10.5.хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох бичиг баримттай танилцах журам, газар
- 2.10.6.хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, цахим шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь.

2.11. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх үед буюу энэхүү журмын 2.8-д заасан хугацаанд хувьцаа эзэмшигчид үндэслэлтэй шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлсэн тэдгээрт заавал танилцуулах баримт бичгийг урьдчилан бүрэн бэлтгэсэн байна. Эдгээр баримт бичигт хувьцаа эзэмшигчид хурлаас гарах



шийдвэрийн төсөл болон дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах газар, санал хураалт явуулах журам, санал өгөх хуудсыг хүлээн авах газар, хувьцаа эзэмшигчдийн санал авах, мэдээлэлтэй танилцах журмыг зөрчсөн тухай санал гомдлыг хүлээж авах этгээдийн харилцах утас, хаяг, саналын хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг тодорхой заасан байна.

2.12. Компани нь хурлын зар хүргэж эхэлсэн өдрөөс эхлэн хурал хуралдах хүртэл хугацаанд хуралд оролцох эрх бүхий этгээдийн нэрсийн жагсаалттай хувьцаа эзэмшигчид танилцах нөхцлийг хангах, хувьцаа эзэмшигчид хурлаар хэлэлцэх гэж буй асуудал, ТУЗ-ын энгийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн талаар саналаа солилцох, боломжийг бүрдүүлнэ.

2.13. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдахаас өмнө сонирхсон хувьцаа эзэмшигч нь хуралд оролцоход саадгүй гэдгээ мэдэх, өөртэй нь холбоотой мэдээлэл үнэн зөв гэдгийг баталгаажуулах, бүртгэлд нэр нь байхгүй, эзэмшиж байгаа хувьцааны тоо, хаяг, регистрийн дугаар нь буруу ташаа байгаа тохиолдолд шалтгааныг тодруулж, мэдээллийн алдааг залруулах зорилгоор гаргасан хүсэлтийн дагуу түүнд хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад нэр нь байгаа эсэх талаар тодорхойлолтыг саадгүй гарган өгнө.

2.14. Хэрвээ хувьцаа эзэмшигч цахим шуудангийн хаягаа нарийн бичгийн даргад өгсөн, хурлын мэдээллийг энэ хаягаараа авахыг хүссэн, бүртгэх өдрөөр нэр нь хувьцаа эзэмшигчийн жагсаалтад байгаа бол бүртгэх өдрөөс хойш 3 хоногийн дотор цахим хэлбэрээр хурлын зар, холбогдох мэдээллийг хүргэнэ.

ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ЗААВАЛ ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

3.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг заавал хэлэлцэнэ. Үүнд:

3.1.1. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт

3.2. Энэ журмын 3.1.1-д заасан тайланд дараах мэдээллийг багтаасан байх ёстой. Үүнд:

3.2.1. компанийн эрхлэн явуулсан үйл ажиллагааны танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүн.

3.2.2. компанийн бүтэц зохион байгуулалт, түүний өөрчлөлт, компанийн хөрөнгийн өөрчлөлтийн тухай тайлан,

3.2.3. тайлангийн хугацаанд эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал, зээл болон бусад хэлбэрээр санхүүгийн дэмжлэг үзүүлсэн, түүнтэй болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй нь аливаа хэлцэл хийсэн бол энэ тухай мэдээлэл

3.2.4. ирэх санхүүгийн жилийн үндсэн зорилт, үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөний талаарх мэдээлэл

3.2.5. Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон бусад нэмэлт мэдээлэл

3.2.6. ТУЗ-ийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлэхээр тогтоосон бусад асуудал

ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ЗААВАЛ ТАНИЛЦУУЛАХ МЭДЭЭЛЭЛ

4.1. Хурлыг үр дүнтэй болгох, хувьцаа эзэмшигчдийн оролцоог идэвхжүүлэх зорилгоор шинжилгээ судалгааны болон хэвлэлийн мэдээлэл, үүний дотор компанийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандсан мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулна.

4.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахаас өмнө дараах мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд заавал танилцуулах бөгөөд хурлын зарыг нийтэд хүргэх үед урьдчилан бэлтгэсэн байна.

4.2.1. энэ журмын 3.2-т заасан мэдээллийг агуулсан компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;

4.2.2. компанийн санхүүгийн тайлан, түүнд Аудитын байгуулагаас өгсөн дүгнэлт болон Гүйцэтгэх удирдлагын зүгээс хийсэн дүн шинжилгээ, түүний талаарх ТУЗ-ийн дүгнэлт;

4.2.3. тайлангийн жилд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай мэдээлэл, тэдгээрийг компанийн тухай хуулийн арванхоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу хийсэн эсэх тухай аудитын байгууллагын дүгнэлт;

4.2.4. компанийн ТУЗ-д нэр дэвшигчдийн тухай танилцуулга;



- 4.2.5. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, түүний эзэмшлийн хувьцааны тухай мэдээлэл;
- 4.2.6. компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал;
- 4.2.7. хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт;
- 4.2.8. компанийн ТУЗ-ийн тайлан, ТУЗ-ийн гишүүн бүрийн үйл ажиллагааны талаар Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт;
- 4.2.9. ирэх санхүүгийн жилийн төлөвлөгөө, төсөв, үндсэн зорилтын талаарх мэдээлэл;
- 4.2.10. компанийг өөрчлөн байгуулах асуудал хэлэлцэх тохиолдолд компанийг өөрчлөн байгуулах үндэслэл, төсөл, өөрчлөн байгуулагдсан тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх болон компанийг өөрчлөн байгуулахад оролцож буй компаниудын /нэгдэх, нийлэх тохиолдолд/ сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан, аудит, үнэлгээний тайлангийн хамт;
- 4.2.11. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах тухай асуудал хэлэлцэхээр товлосон бол оруулж буй өөрчлөлтийн тухай санал болон уг өөрчлөлтийг оруулж буй шалтгааны тухай тайлбар;
- 4.2.12. компанийн өрийг хувьцаагаар солих тухай асуудал хэлэлцэх бол өр үүссэн болон өрийг төлөх боломжгүй болсон шалтгаан, өрийг хувьцаагаар солихдоо нэгж хувьцааг ямар үнээр тооцож солих тухай мэдээлэл, түүний үндэслэл тооцоо, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт;
- 4.2.13. нэмж хувьцаа гаргах тухай асуудал хэлэлцэх бол хувьцаа нэмж гаргах замаар нэмж санхүүжилт татах зорилго, хэмжээ, гаргах хувьцааны тоо, гаргаж санал болгох үнэ, энэхүү үнийг тогтоосон үндэслэл тооцоо компанийн болон хувьцааны үнэлгээний талаари хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт, хувьцааг хаалттай хүрээнд санал болгох бол хэнд, ямар учраас санал болгож байгаа тухай дэлгэрэнгүй мэдээлэл, хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг эдлүүлэх эсэх тухай, эдлүүлэхгүй байх санал оруулж байгаа бол шалтгаан;
- 4.2.14. хувьцааг хуваах болон нэгтгэх асуудал хэлэлцэх бол шалтгаан, хувьцааг хөрвүүлэх харьцаа, түүнийг тогтоосон үндэслэл тооцоо, бутархай үлдэгдлийг худалдан авах үнэ, хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт;
- 4.2.15. их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай асуудал хэлэлцэх бол их хэмжээний хэлцлийн тухай танилцуулга, агуулга, уг хэлцлийг хийх болсон шалтгаан, үр дагаварын талаар ТУЗ-ийн дүгнэлт;
- 4.2.16. сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай асуудал хэлэлцэх бол уг хэлцлийн тухай танилцуулга, хэлцэл хийх зайлшгүй шаардлага, Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан сонирхлын зөрчил бүхий этгээд (компанийн эрх бүхий албан тушаалтан буюу компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч зэрэг)- ийн нэр, албан тушаал буюу сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдал, хэлцлийн үнийн тухай санал;
- 4.2.17. компани өөрийн хувьцааг эргүүлэн авахыг зөвшөөрөх тухай асуудал хэлэлцэх бол эргүүлэн авах хувьцааны тоо хэмжээ, үнэ, уг хэлцэл хийх болсон шалтгаан, худалдан авах эх үүсвэрийн тухай танилцуулга;
- 4.2.18. ТУЗ-д нэр дэвшиж буй ердийн болон хараат бус гишүүдийн товч намтар, ажлын туршлага, мэдлэг боловсрол, ур чадвар, Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын сургалтанд сууж, гэрчилгээ авсан тухай мэдээлэл;
- 4.2.19. ТУЗ-ийн нарийн бичгийн талаарх мэдээлэл, түүний цахим шуудангийн хаяг, утас;
- 4.2.20. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэр, хуваарилах бол нэгж хувьцаанд хуваарилахаар санал болгож буй ногдол ашгийн хэмжээ, түүнийг тогтоосон үндэслэл тооцоо, ногдол ашгийг олгож эхлэх хугацаа, хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол түүний үндэслэл, тооцоо.

4.3. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултанд хариулж, тодруулга хийх үүрэгтэй тул хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад энэ асуудлыг заавал тусгана.

ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛД САНАЛ АВАХ ЖУРАМ

5.1. Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ-ийн гишүүний нэр дэвшүүлэх



хүний талаархи саналаа хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтанд оруулахаар, жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, эсхүл гүйцэтгэх удирдлагад бичгээр ирүүлнэ.

5.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтанд оруулах саналд дараахь зүйлсийг тодорхой заасан байна. Үүнд:

5.2.1. хэлэлцүүлэхээр санал болгож буй асуудлын томъёолол;

5.2.2. асуудлыг хэлэлцүүлэхээр оруулж байгаа шалтгаан;

5.2.3. уг асуудлаар гарах шийдвэрийн төсөл;

5.2.4. санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчийн овог, нэр, хаяг, эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо.

5.3. Хэрэв санал гаргагч этгээд нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлж байгаа бол нэрийг нь дэвшүүлж байгаа этгээдийн овог, нэр, компанийн ТУЗ-ийн гишүүнд тавих шаардлагыг хэрхэн хангаж байгаа тухай мэдээлэл, түүнийг нотлох баримт, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүний алинд нь нэр дэвшүүлж байгааг тусгасан байна. Саналд компанийн “ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам”-ын 3-1-р хавсралтаар баталсан “Нэр дэвшигчийн зөвшөөрөл”, 3-2-р хавсралтаар баталсан “Нэр дэвшигчийн анкет” зэргийг хавсаргасан байна.

5.4. Энэ журмын 5.1-дах саналыг ТУЗ-ын дарга, компанийн гүйцэтгэх удирдлага хүлээн авсан бол нэн даруй ТУЗ-ийн нарийн бичгийн даргад шилжүүлнэ. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь санал ирүүлсэн этгээд нь ийнхүү санал гаргах бүрэн эрхтэй эсэх, хэлэлцүүлэхээр санал болгож байгаа асуудал нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах эсэх, ТУЗ-д нэр дэвшүүлж байгаа бол нэр дэвшигч нь компанийн ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэх, ирүүлсэн мэдээлэл нь бодитой, бүрэн ирүүлсэн эсэх тухай танилцуулгыг 3 хоногийн дотор бэлтгэж, хувьцаа эзэмшигчийн саналын хамт ТУЗ-ийн даргад, хэрэв ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлж байгаа бол Нэр дэвшүүлэх хорооны даргад шилжүүлнэ.

5.5. ТУЗ-ийн дарга тухайн асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах боломжтой гэж үзвэл холбогдох бэлтгэлийг хангуулан хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар ТУЗ-ийн хуралд оруулна. Харин ТУЗ-д нэр дэвшүүлж байгаа бол Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-аар хэлэлцүүлнэ. Саналыг хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах боломжгүй гэж үзвэл үндэслэл бүхий хариуг санал гаргасан хувьцаа эзэмшигчид санал ирүүлснээс хойш ажлын 5 хоногт багтаан бичгээр хүргүүлнэ.

5.6. ТУЗ-ийн дарга нь зөвхөн дараах нөхцөлд саналыг хүлээн авахаас татгалзана.

5.6.1. санал гаргагч нь нийт гаргасан энгийн хувьцааны 5-аас бага хувийг эзэмшдэг;

5.6.2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь Компанийн тухай хууль, компанийн дүрэм, журмаар тогтоосон шаардлага хангаагүй

5.6.3. энэ журмын 5.2-т заасан мэдээллийг бүрэн тусгаагүй;

5.6.4. хэлэлцүүлэхээр санал болгож буй асуудал нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй асуудал байсан эсхүл хурлаар хэлэлцэх асуудалтай давхцсан бол.

5.7. ТУЗ хувьцаа эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр гаргасан саналыг нь өөрчлөх эрхгүй.

5.8. Энэ журмын 5.6-д дурдсан ТУЗ-ын шийдвэрийн талаар санал гаргагч шүүхэд гомдол гаргаж болно.

ЗУРГАА. ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ, ХУРЛЫН ДЭГ

6.1. Хурлыг товлосон өдөр, цагт, товлосон газарт хуралдуулна.

6.2. Хурлын бэлтгэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан хангах бөгөөд хурал зохион байгуулах комисс /хурал зохион байгуулах комиссын үүргийг ТУЗ-өөс томилогдсон тооллогын комисс гүйцэтгэнэ/ бүхий л талаар туслалцаа үзүүлж гүйцэтгэх захирал хяналт тавина.

6.3. Хурал хуралдахын өмнө хурлын байр, техник хэрэгсэл, ширээ сандал, санал авах хуудас, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах материал зэргийг хүрэлцэхүйц хэмжээгээр бүрэн бэлдсэн байна.



6.4. Хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийг бүртгэх, хуралтай холбогдох материал болон саналын хуудсыг тараах ажиллагааг хурал зохион байгуулах комиссын гишүүд хариуцан гүйцэтгэнэ. Ирсэн хувьцаа эзэмшигч бүрийн бүртгэлд байгаа нэр хаяг, регистрийн дугаар зөв эсэхийг тодруулан холбогдох залруулга хийхийн зэрэгцээ тэдний цахим шуудангийн хаягийг тэмдэглэн авч, хүргэх мэдээллийг цахим шуудангаар авахыг зөвшөөрч байгаа, цахим хаяг өөрчлөгдвөл нэн даруй ТУЗ-ын нарийн бичгийн даргад мэдэгдэх, тийнхүү мэдэгдээгүйгээс үүсэх үр дагаврыг компани хариуцахгүй болохыг таниулан тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

6.5. Хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигч нь иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах бичиг баримтаа авч ирсэн байна.

6.6. Өөрийн гэр бүлийн, насанд хүрээгүй гишүүдийг төлөөлөн оролцож байгаа бол иргэний үнэмлэх, хүүхдийн гэрчилгээ зэрэг бичиг баримттай ирнэ.

6.7. Хувьцаа эзэмшигч өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж болох бөгөөд уг этгээд нь энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ. Хэрэв өөр хувьцаа эзэмшигчийн саналын хуудсыг хуралд авч ирсэн бол саналын хуудсыг тухайн этгээд өөрөө бөглөж, гарын үсэг зурж иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах бичиг баримтын хуулбарыг хавсаргасан байна.

6.8. Хурлын тооллогын комиссын протоколд тухайн этгээд хувьцаа эзэмшигчийг төлөөлөн итгэмжлээр оролцсон эсэх, саналын хуудсыг төлөөлөн авч ирсэн эсэх эсхүл гэр бүлийн насанд хүрээгүй гишүүнийг төлөөлөн оролцсон эсэхийг заавал тэмдэглэнэ.

6.9. Биеийн байцаалтгүй хувьцаа эзэмшигчийг компанийн хувьцаа эзэмшигч мөн болохыг тухайн хуралд оролцож байгаа 3-аас илүү хувьцаа эзэмшигч гэрчилсэн тохиолдолд хуралд оролцуулж болно.

6.10. Хурал даргалагч нь хуралд ирсэн хувьцаа эзэмшигчийг аль болох оролцуулах арга хэмжээг авах үүрэгтэй.

6.11. Хурал эхлэхэд тооллогын комисс хуралд саналын эрх бүхий хэдэн энгийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирснийг мэдэгдэх бөгөөд нийт саналын эрхийн 51 болон түүнээс дээш хувийг эзэмшигчид хүрэлцэн ирсэн /биеэр, итгэмжлэлээр, саналын хуудсаар/ тохиолдолд хурлын ирч хүчин төгөлдөр болсон гэж үзэж хурлыг эхлүүлнэ.

6.12. Хурлын ирцэнд заасан хувьд хүрээгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг хойшлуулан, дахин хуралдах өдрийг товлон. Хурлын ирцийн талаар болон хурлыг хүчин төгөлдөр гэж үзэх эсэх тухай тооллогын комисс тогтоол гаргаж, албажуулан, комиссын дарга гарын үсэг зурсан байна.

6.13. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдан явуулах этгээдийг компанийн дүрмийн 7.4 дэх заалтын дагуу сонгоно.

6.14. Хуралд ТУЗ-ийн бүх гишүүд, гүйцэтгэх удирдлагын, компанийн дүрмээр эрх бүхий албан тушаалтан гэж тодорхойлсон бүх албан тушаалтнууд болон ТУЗ-д нэр дэвшиж байгаа бүх хүмүүс оролцож, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулна. Хуралд ирээгүй албан тушаалтны ирээгүй шалтгааныг ТУЗ-ийн дарга танилцуулна.

6.15. Хурлаар хэлэлцэхээр товлосон бүх асуудлыг танилцуулж дууссаны дараа хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн асуултад холбогдох албан тушаалтан тодорхой хариулт өгнө. Хурлын явцад тодорхой хариулт өгөх боломжгүй асуулыг протоколд тэмдэглэн, хариулыг бэлтгэн хэн хариуцан, хэдийд хувьцаа эзэмшигчийн хаягаар хүргүүлэхийг хурал даргалагч мэдээлнэ. Нийт хувьцаа эзэмшигчдэд хамааралтай асуудал бол хариулыг компанийн цахим хуудсанд тогтоосон хугацаанд тавихаар зарлана.

6.16. Асуулт хариулт дууссаны дараа хувьцаа эзэмшигчид санал, хүсэлт гаргана. Асуулт, хариулт, санал хүсэлт бүрийг хурлын протоколд дэлгэрэнгүй тэмдэглэнэ.



6.17. Санал хүсэлт нь өмнө нь үг хэлсэн хувьцаа эзэмшигчдийнхтэй давхардсан, хурлын дэгээр тогтоосон хугацаанаас хэтэрсэн бол саналаа бичгээр ирүүлэхийг сануулж, үг хэлэх эрхийг дараагийн хувьцаа эзэмшигчид шилжүүлнэ.

6.18. Хурал даргалагч нь өөрийн санал бодлыг тулгах, энэ журмын 6.17-д зааснаас бусад тохиолдолд хэлэх үгийг таслах, тайлбар хэлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд ямар нэгэн дарамт учруулахыг хориглоно.

6.19. Хурлаар хэлэлцэх асуудал дууссаны дараа саналын хуудсыг бүрэн хураан авч, ТУЗ-ийн хурлаас томилогдсон тооллогын комисс саналыг тоолно. ТУЗ-ийн гишүүн сонгохоос бусад асуудлыг Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасны дагуу саналын дийлэнх эсхүл олонхиор шийдвэрлэнэ.

6.20. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхдээ тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүний тоогоор үржүүлж саналын эрхийн тоог тодорхойлно. ТУЗ-ийн гишүүнд сонгогдохоор нэр дэвшсэн хүмүүсийн нэрийг саналын хуудсанд оруулахдаа ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүсийн нэрсийг тус тусад нь жагсаана. Хувьцаа эзэмшигч нь ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүст тус тусад нь саналаа өгнө. ТУЗ нь 9 гишүүнтэй байхаар компанийн дүрэмд заасан учраас ердийн гишүүнд нэр дэвшиж буй 1-6 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 2/3-ийг, хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 1-3 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 1/3-ийг дурын тоогоор хуваарилан өгсөн байна. Энэ хуваарийг зөрчиж санал өгсөн бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.

6.21. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг компанийн дүрмийн 7.14 заалтын дагуу хөтөлж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

6.22. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын материал, гаргасан шийдвэрийн хувийг ээлжит хурлын хувьд жил бүрийн 6 дугаар сарын 1-ний дотор, ээлжит бус хурлын хувьд хурал хуралдсанаас хойш 20 хоногийн дотор тус тус Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

6.23. ТУЗ-ын нарийн бичгийн дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг Хурал хуралдсанаас хойш ажлын 15 хоногийн дотор компанийн цахим хуудсанд тавина.

ДОЛОО. САНАЛЫН ХУУДСААР САНАЛ АВАХ

7.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авна.

7.2. Саналын хуудасны агуулга, загварыг хурал зарласан этгээд батална.

7.3. Саналын хуудсанд дараах зүйлийг тусгана. Үүнд:

7.3.1. компанийн оноосон нэр;

7.3.2. хурал хийх газар, өдөр, цаг;

7.3.3. хувьцаа эзэмшигчийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, түүний эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо;

7.3.4. санал хураалтаар шийдвэрлэх асуудлын томьёолол, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн эцэг эхийн нэр, өөрийн нэр болон ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа алин болох тухай;

7.4. Сонгуульд ердийн журмаар саналаа өгөхөд асуудал бүрээр "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" аль нь болохыг тэмдэглэсэн саналын хуудсыг, кумулятив аргаар санал өгөхөд уг аргын тухай тайлбар бүхий тухайн нэр дэвшигчид өгөх саналын тоог тус тус тэмдэглэсэн саналын хуудсыг хэрэглэнэ. Саналын хуудсаны арын нүүрэнд санал өгөх журмыг тодорхой тайлбарласан байна.

7.5. Саналын хуудсаар өгсөн саналыг дараах тохиолдолд хүчинтэйд тооцно. Үүнд: 7.5.1. ердийн журмаар санал өгөх асуудалд санал өгөх 3 хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн;

7.5.2. кумулятив аргаар санал хураан сонгох төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч бүрд өгсөн саналын тооны нийлбэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн саналын эрхийн тооны нийт



дүнгээс илүүгүй байх бөгөөд саналын эрхийн нийт дүн нь тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа саналын эрх бүхий энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

НАЙМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

- 8.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор хурлын тэмдэглэлийг энэ журмын 6.21-дагуу гаргаж, уг тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.
- 8.2. Хурлын тэмдэглэлд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:
- 8.2.1. хурал болсон газар, он, сар, өдөр, цаг;
 - 8.2.2. хурлын даргын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
 - 8.2.3. хурлаар хэлэлцсэн асуудлын жагсаалт;
 - 8.2.4. хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо, хурлын ирц;
 - 8.2.5. саналын хуудасны загварыг хавсаргана;
 - 8.2.6. хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу тайлан тавьж, танилцуулга хийсэн эрх бүхий албан тушаалтан, аудит, хөндлөнгийн мэргэжилтний мэдээлэл;
 - 8.2.7. санал гаргасан, асуулт асуусан хувьцаа эзэмшигчдийн санал, асуулт;
 - 8.2.8. хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, гаргасан шийдвэрийн бүрэн томьёолол.
- 8.3. Хурлын тэмдэглэлд алдаа гарсан нь хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.
- 8.4. Хурлаас гарсан шийдвэрийг санал хураах хуудсыг тоолсон тухай тооллогын комиссын шийдвэр гарсаны дараа хуралд оролцогчдод сонгсоно.
- 8.5. Хурлын тэмдэглэл үнэн зөв болохыг баталгаажуулахын тулд аудио, видео техник хэрэгсэл ашиглан бичлэг хийж болно. Хувьцаа эзэмшигч бичлэг хийх санал гаргасан тохиолдолд хурлын дарга зөвшөөрөл олгох үүрэгтэй. Хувьцаа эзэмшигч дээрх саналаа хурал хуралдахаас 3-аас доошгүй хоногийн өмнө бичгээр ирүүлнэ. Энэ тохиолдолд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан хурал дууссан даруйд уг бичлэгийн хувийг хуулбарлан авч хадгална.

ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС

- 9.1. Хурал хуралдуулах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд тооллогын комиссыг томилно.
- 9.2. Тооллогын комиссын үүргийг хурал зохион байгуулахаар гэрээ байгуулсан брокер, дилерийн компаниар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж болно.
- 9.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийг тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно.
- 9.4. Тооллогын комисс дараах үүрэгтэй байна. Үүнд:
- 9.4.1. Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийг /биеэр, итгэмжлэлээр, саналын хуудсаар/ бүртгэн, ирцийг тогтоож /барьцаалагдсан, шүүхийн битүүмжлэлтэй үнэт цаасны саналын эрх хязгаарлагдахгүй/, тооллогын комиссын тогтоол гарган хуралд оролцогчид болон хурлын даргад мэдэгдэх
 - 9.4.2. Тухайн хурлын хэлэлцэх асуудал бүрээр оролцогч бүрийн саналын эрхийн тоо, төрлийг тогтоох /хуульд заасан үндэслэлээр болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр саналын эрхгүй болсон хувьцаа эзэмшигч байгаа бол ТУЗ энэ тухай нотлох баримтыг бүрдүүлж хуралд оролцогчдод мэдээлнэ. Хувьцаа эзэмшигч бүртгэлийн өдрөөс хойш хурал хуралдах өдөр хуртэл хугацаанд саналын эрхээ сэргээсэн тухай нотлох баримтаар батлаагүй бол тэрээр саналын эрх эдлэхгүй /;



- 9.4.3. Хуралд оролцогчдод санал өгөх эрхээ хэрэгжүүлэх талаар тайлбарлаж, санал өгөх эрхийг хангах;
- 9.4.4. Саналын хуудсыг хүлээн авч тоолох;
- 9.4.5. Санал хураалтын дүнг тодорхойлж, энэ тухай тэмдэглэл хөтлөн, шийдвэр гаргах /шийдвэрт тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна/;
- 9.4.6. Саналын хуудсыг компанийн архивт хадгалуулахаар шилжүүлэх.

9.5. Тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнгийн үнэн зөвийг хариуцна.

9.6. Тооллогын комисс нь хурал зохион байгуулах комиссын үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

9.6.1. Хурлын өмнө хувьцаа эзэмшигчдэд танилцуулах мэдээллийг бэлэн болгох асуудлаар гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргад зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлнэ; 9.6.2. Хурлын материалыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг БДК-д хүргүүлэх, хувьцаа эзэмшигчдийн бөглөсөн саналын хуудсыг хүлээн авах зэрэгт туслалцаа үзүүлнэ.

АРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ, ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТ

10.1. Шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ТУЗ зарлан хуралдуулна.

10.2. ТУЗ-ийн 2-оос цөөнгүй хараат бус гишүүн, нийт гаргасан энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа этгээд шаардлага гаргасан бөгөөд хэлэлцүүлэхээр санал болгож байгаа асуудал нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн асуудал бол ТУЗ ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг энэ журмын 2 дугаар зүйлд заасны дагуу гаргаж, зарлан хуралдуулна.

10.3. Хууль болон компанийн дүрмээр тогтоосон Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцүүлэхээр ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий хувьцаа эзэмшигч ээлжит бус хурал хуралдуулах санал гаргасан тохиолдолд ТУЗ хурлыг заавал зарлан хуралдуулах үүрэгтэй бөгөөд хурлын зар мэдээг энэ журамд заасны дагуу хүргэнэ. Харин хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдэд хүргэх мэдээллийг хурал зарлагч болон ТУЗ, нарийн бичгийн дарга нар хамтран бэлтгэж, хувьцаа эзэмшигчдэд энэ журамд заасны дагуу хүргэнэ.

10.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Харин хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй.

10.5. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт Компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.

10.6. Эчнээ санал хураалтаар асуудал шийдвэрлэх үед эчнээ санал хураалтын зар мэдээг хурлын зар мэдээг хүргэхээр энэ журмаар тогтоосны дагуу хүргэх бөгөөд, саналын хуудсыг хувьцаа эзэмшигчийн цахим шуудангийн хаягаар болон энэ журамд заасны дагуу хүргэн, санал авах эцсийн хугацааг мэдээлсэн байна.

10.7. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.

10.8. Саналын хуудсыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор санал хураасан дүн, санал хураалтын тайланг тооллогын комисс гаргаж, ТУЗ-д хүргэнэ.

10.9. ТУЗ нь энэхүү дүрмийн 7.18-д заасан тайланд үндэслэн шийдвэр гаргаж, шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд гарсан шийдвэрийн тухай мэдээллийг хурлын зар мэдээг хүргэдэг аргаар хүргэнэ. 10.10. Эчнээ санал хураалтын дүнгээр гаргасан шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо, МХБ-д тус бүр нэг хувийг хүргүүлнэ.



10.11. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн тухай хуулийн 69.3-аас 69.9-т заалтуудын дагуу хуралдуулна.

АРВАН НЭГ. ХАРИУЦЛАГА

11.1. Хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, ялангуяа ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, хурлын зар мэдээг хүргэх, хувьцаа эзэмшигчдэд заавал хүргэх мэдээллийг хүргэх, хурлыг энэ журамд заасны дагуу хуралдуулах зэрэг асуудлыг ТУЗ-ийн дарга биечлэн хянаж, тухай бүр холбогдох арга хэмжээ авч байна.

11.2. Энэ журмыг зөрчсөн буруутай этгээдэд гүйцэтгэх удирдлага буюу ТУЗ-ийн шийдвэрээр хариуцлага хүлээлгэнэ.

11.3. Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх” журам, энэ журмыг зөрчсөнөөс Компанийн тухай хуулийн 100 дугаар зүйлд заасны дагуу торгууль хүлээсэн бол ТУЗ буруутай эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шийдвэрлэж болно.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга  Д. Нямхүү

Гишүүд: Хамхоев.Х.Ю

..... Д. Мөнхөө

..... Л. Адилбиш

..... Громов С.Б.

..... Д. Дэлэг

..... М.Батбаатар

..... Мирзоев Р.Г

..... Ж.Батсайхан

Монгол улсын Санхүүгийн Зохицуулах хорооны
2012 он 02 дугаар сарын 15-ны өдрийн
34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр

Хаяг, утас

Хурал хуралдах огноо, цаг, газар

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо

Олон нийтэд зарлах огноо

Бүртгэх өдөр

Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо

Хүргүүлсэн огноо

Хурлын баримт, бичгийн хуудсын тоо ширхэг, хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

КОМИССЫН ДАРГА /

оны дүгээр сарын -ний өдөр

ХҮЛЭЭН АВСАН :

БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН /

оны дүгээр сарын -ний өдөр

Дээрх мэлээллийг, хавсралт материалын хамт 2 хувь үйлдэж, Санхүүгийн зохицуулах хороо, ҮЦТТХТ \компани нээлттэй болсны дараа Монголын хөрөнгийн бирж\ -д хүргүүлнэ.